



Долоо хоног тутмын хэвлэл  
2015 оны 12 дугаар сарын 18  
№47 /908/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

2078

Монгол Улсын  
хууль

2101

Монгол Улсын Их  
Хурлын тогтоол

2109

**Хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн тухай**

**Эрчим хүч хэмнэлтийн тухай**

**Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн  
талаар баримтлах бодлого  
батлах тухай**

**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

547.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай	2078
548.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2094
549.	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2095
550.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2095
551.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2096
552.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2097
553.	Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2097
554.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2098
555.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2098
556.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2099
557.	Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2099
558.	Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2100
559.	Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2101
560.	Эрчим хүч хэмнэлтийн тухай	2101
561.	Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2108
562.	Зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай	2109

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

563.	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 104	2109
------	---	------------	------



564.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 105	2118
565.	Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 106	2119
566.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай	Дугаар 107	2120
567.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 109	2120
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>			
568.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 180	2121
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
569.	Гэрээний загвар батлах тухай	Дугаар 430	2121
<b>МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ</b>			
570.	Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 11	2125
<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>			
2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр		Улаанбаатар хот	
<b>ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ</b>			
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b>			
<b>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</b>			
<p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.</p>			



## **2 дугаар зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж**

2.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль<sup>2</sup>, Төсвийн тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

## **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх, хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

## **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэж Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.2.“аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт” гэж бүсчилсэн хөгжлийн бодлогод суурилсан, орон нутгийн онцлогийг харгалзан, байгаль орчны тогтвортой байдлыг хангасан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилго, зорилтыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.3.“бүсчилсэн хөгжлийн бодлого” гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүс нутаг, хот байгуулалтын уялдаа, байгаль орчны тогтвортой байдлыг хангах замаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.4.“дэд хөтөлбөр” гэж Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгийг;

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Төсвийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.



4.1.5. “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж бүсчилсэн хөгжлийн бодлого болон аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилгод суурилсан, орон нутгийн сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийг тусгасан, орон нутгийн хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.6. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогод суурилсан, Улсын Их Хурлын сонгуулиар олонх суудал авсан улс төрийн нам, улс төрийн намуудын эвслийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдсан, хөгжлийн дунд хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.7. “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, эдийн засаг, нийгмийн хөгжлийг ахисан түвшинд хүргэх, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангахад чиглэсэн баримт бичгийг;

4.1.8. “төрөөс баримтлах бодлого” гэж Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, түүнд заасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд салбарын болон салбар хоорондын хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.9. “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;

4.1.10. “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.11. “үндэсний хөтөлбөр” гэж төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.12. “хөгжлийн бодлогын баримт бичиг” гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх



үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичгийг.

### **5 дугаар зүйл.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим**

5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- 5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 5.1.5.нөөц бололцоонд үндэслэсэн байх;
- 5.1.6.ил тод, нээлттэй байх;
- 5.1.7.олон нийтийн оролцоог хангасан байх.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

#### **6 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл**

6.1.Хөгжлийн бодлогын баримт бичиг нь дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран дараах төрөлтэй байна:

- 6.1.1.урт хугацааны;
- 6.1.2.дунд хугацааны;
- 6.1.3.богино хугацааны.

6.2.Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.

6.3.Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

- 6.3.1.төрөөс баримтлах бодлого;
- 6.3.2.бүсчилсэн хөгжлийн бодлого;
- 6.3.3.аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.

6.4.Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

- 6.4.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- 6.4.2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- 6.4.3.үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;
- 6.4.4.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.



6.5.Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:

6.5.1.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;

6.5.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;

6.5.3.Энэ хуулийн 6.5.1-д заасан үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв.

6.6.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газар батална.

### **7 дугаар зүйл.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал**

7.1.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжил, тэгш, хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг нөөц, эх үүсвэртэй нь уялдуулан тооцсон хөгжлийн загварт суурилсан байна.

7.2.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах талаар Улсын Их Хурлаас өгсөн чиглэлийн дагуу удирдамж гаргаж, төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна.

7.3.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэдийн оролцоог ханган боловсруулна.

7.4.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

7.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.5-д заасан тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.



7.7.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

7.8.Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулна.

7.9.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна.

7.10.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхийг Үндэсний аудитын газар хянаж, Сонгуулийн ерөнхий хороонд дүгнэлтээ хүргүүлнэ.

## **8 дугаар зүйл.Төрөөс баримтлах бодлого**

8.1.Төрөөс баримтлах бодлого нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын тэргүүлэх чиглэлийг дунд хугацаанд салбарын болон салбар хоорондын түвшинд цогц байдлаар хэрэгжүүлэх төрийн бодлогын чиглэл, үйл ажиллагааны зарчим, залгамж чанарыг хадгалсан байна.

8.2.Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрөөс баримтлах бодлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

8.3.Төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулахдаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангана.

8.4.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

8.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.





8.6. Төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

## **9 дүгээр зүйл. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр**

9.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн болон бодит салбарын өсөлтийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг хангах, нийгмийн хөгжлийн хүртээмжийг дээшлүүлэх, байгаль орчинд ээлтэй эдийн засгийн хөгжлийг хангах, хүн амын амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэнэ.

9.2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

9.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газар батална.

9.4. Төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

9.5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, энэ хуулийн 9.4-т заасан тайлан болон хөндлөнгийн үнэлгээний тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

9.6. Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

## **10 дугаар зүйл. Үндэсний хөтөлбөр**

10.1. Үндэсний хөтөлбөрт төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн байна.



10.2.Өмнө батлагдсан ижил төстэй үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилт, агуулгын хүрээнд шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг энэ хуулийн 9.3-т заасан төлөвлөгөөний хамт Засгийн газар батална.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад орсон үндэсний хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

10.4.Салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулна.

10.5.Үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсөв болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгана.

10.6.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.

10.7.Төрийн захиргааны төв байгууллага жил бүр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт танилцуулна.

## **11 дүгээр зүйл. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр**

11.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

11.2.Жил бүрийн улсын төсөв, төсвийн тодотголд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт заасан төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийн болон урсгал зардлын санхүүгийн эх үүсвэрийг тусгаж байна.

11.3.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөж, батлахад Төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлийг баримтална.

11.4.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.



## **12 дугаар зүйл. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл**

12.1. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэслэн боловсруулна.

12.2. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн холбогдох заалт, зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусгасан байна.

12.3. Нутгийн захиргааны байгууллага нь үндэсний хэмжээний бодлогын чанартай арга хэмжээ болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хязгаарыг хангаж байгаа төсөл, арга хэмжээний саналыг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулахаар жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн захиргааны төв байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.4. Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналыг тусган, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

12.5. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан тухайн салбарын зарлагын дээд хязгаараас хэтрэхгүй байна.

12.6. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг хүлээн авч нэгтгэн, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газарт хүргүүлнэ.

12.7. Засгийн газар улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хянан хэлэлцэж, жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.



12.8.Улсын Их Хурал Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэн батална.

12.9.Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

12.10.Засгийн газар улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

### **13 дугаар зүйл.Бүсчилсэн хөгжлийн бодлого**

13.1.Бүсчилсэн хөгжлийн бодлого нь байгалийн баялаг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглах үндсэн дээр хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулах, төвлөрлийг сааруулах, аймаг, бүс нутаг хоорондын хөгжлийн түвшинг ойртуулах, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэхэд чиглэнэ.

13.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.

13.3.Бүсчилсэн хөгжлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай<sup>4</sup>, Хот байгуулалтын тухай<sup>5</sup> хуультай уялдуулан боловсруулна.

13.4.Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх ба бүс нутгийн хөгжлийг хангах зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлсон байна.

13.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.

<sup>4</sup> Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Хот байгуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



13.6.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт хүргүүлнэ.

#### **14 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт**

14.1.Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиглэлийн дагуу аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

14.2.Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон мэргэжлийн холбоодыг оролцуулан зохион байгуулж болно.

14.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн, Засаг даргын саналыг үндэслэн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийг баримтална.

14.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

14.5.Сум, дүүргийн түвшинд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх орон нутгийн онцлогийг тусгасан хөгжлийн дунд хугацааны бодлоготой байж болно.

14.6.Нутгийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

#### **15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр**

15.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.



15.2.Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг, түүнийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

15.3.Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо Төсвийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт заасныг мөрдөнө.

15.4.Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.

15.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын бүрэн эрхэд үл хамаарах асуудал болон хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй, үндэслэлгүй зорилт, арга хэмжээг тусгахыг хориглоно.

15.6.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг төсөв, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан, дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

15.7.Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

15.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

## **16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл**

16.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна.

16.2. Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-



ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

16.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.

16.4.Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна.

16.5.Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА, САНХҮҮЖИЛТ**

#### **17 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үе шат, тавигдах шаардлага**

17.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг доор дурдсан дарааллын дагуу боловсруулна:

17.1.1.хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох, холбогдох тоон болон чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

17.1.2.асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, гарах үр дүн, үр нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөлд үндэслэн бодлогын хувилбарыг боловсруулах;

17.1.3.бодлогын хувилбарыг доорх шалгуурын дагуу үнэлж, оновчтой хувилбарыг сонгоно:

17.1.3.а.дэлхий нийтийн болон бүс нутгийн хөгжлийн хандлага, хамтын ажиллагааг харгалзан өөрийн орны хөгжлийн онцлогийг тусгасан эсэх;

17.1.3.б.эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэрт байдалд суурилан тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэх;

17.1.3.в.олон нийтийн эрх, ашиг сонирхолд нийцсэн эсэх;



17.1.3.г.тэгш, хүртээмжтэй байдлыг хангасан эсэх;  
17.1.3.д.бодлогын үр ашиг, хэрэгжих үндэслэл бодитой эсэх.

17.1.4.хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна.

17.2.Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх, түүнд тусгагдсан төсөв, санхүүгийн тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

### **18 дугаар зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр**

18.1.Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.

18.2.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байна:

- 18.2.1.улсын болон орон нутгийн төсөв;
- 18.2.2.гадаадын зээл, тусламж;
- 18.2.3.гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 18.2.4.Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас;
- 18.2.5.концессын гэрээ;
- 18.2.6.бусад эх үүсвэр.

### **19 дүгээр зүйл.Олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах**

19.1.Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг хэвлэн нийтлэх, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулж болно:





- 19.2.1.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;  
19.2.2.эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;  
19.2.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;  
19.2.4.төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.

19.3.Холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.2-т заасан хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, төслийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД**

### **20 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

20.1.Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэгч байгууллага нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвийн багцад тусгаж, батлуулсан байна.

20.2.Энэ хуулийн 7-16 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг Засгийн газар батална.

### **21 дүгээр зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

21.1.Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

21.1.1.хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон;

21.1.2.гадаад, дотоод орчны нөлөөлөл, хүчин зүйлээс шалтгаалан улсын эдийн засаг, нийгэм, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн;

21.1.3.Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон.



21.2. Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлнэ.

21.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн үр дүн нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

21.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

## **22 дугаар зүйл. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэвлэн нийтлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, арга зүйн удирдамжаар хангах**

22.1. Батлагдсан хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, хэвлэх, сурталчлах ажлыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

22.2. Төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нэгтгэсэн эмхэтгэлийг жил бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.

22.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлогыг уялдуулан зохицуулах хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө.

22.4. Энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална.

22.5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлнэ.



22.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ Бодлогын судалгааны хүрээлэн ажиллуулж болно.

**23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг Төрийн албаны тухай<sup>6</sup>, Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд зааснаар зохицуулна.

**24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Засгийн газрын” гэсний өмнө “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл зэрэг баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд түүнд өргөн мэдүүлнэ.” гэснийг “Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн

<sup>6</sup> Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.



төлөвлөгөөний” гэснийг “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийн” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “эдийн засгийн өсөлтийг” гэснийг “эдийн засаг, нийгмийн хөгжлийг” гэж, мөн зүйлийн 28.3.7 дахь заалтын “бүс нутгийн хөгжлийн бодлого” гэснийг “бүсчилсэн хөгжлийн бодлого” гэж, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “Улсын Их Хурлаас баталсан төрийн бодлогын баримт бичгийн” гэснийг “Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “бүсийн хөгжлийн хөтөлбөрийг батлах, бүсийн хөгжлийн стратегийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэснийг “бүсчилсэн хөгжлийн бодлого, бүсийн хөгжлийн



хөтөлбөрийг батлах” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.9 дэх заалтын “бүс нутгийн хөгжлийн бодлогод” гэснийг “бүсчилсэн хөгжлийн бодлогод” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтын “аймаг, нийслэлийн болон сумын хөгжлийн хөтөлбөр” гэснийг “аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт болон сумын хөгжлийн дунд хугацааны бодлого” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн хөгжлийн стратегитэй” гэснийг “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлоготой” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын а/-д “эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэлийг” гэснийг “хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг” гэж, 18.1.2 дахь заалтын е/-д “бүсчилсэн хөгжлийн стратегитэй” гэснийг “бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын а/-д “болон жилийн үндсэн чиглэлийн” гэснийг “зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.2.Энэ хуулийн 5.1-д заасан арга хэмжээг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хот байгуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл” гэснийг “бүсчилсэн хөгжлийн бодлого” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “төсөл, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах, тэдгээрт” гэснийг “төсөл, түүнд” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “бүс нутгийн” гэснийг “бүсийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн “мөрийн хөтөлбөрөө” гэсний дараа “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон уг хөтөлбөрийг” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“32.1.Нэр дэвшигч нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд үзэл баримтлалаа тодорхойлсон сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байх бөгөөд мөрийн хөтөлбөр нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын биелэлтийг хангахад чиглэсэн байна.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийн “хөтөлбөрөө” гэсний дараа “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд болон” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“34.1.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байх бөгөөд мөрийн хөтөлбөр нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын биелэлтийг хангахад чиглэсэн байна.”



**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийн “мөрийн” гэсний дараа “хөтөлбөрөө Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлсэн эсэхэд” гэж, мөн хэсгийн “хөтөлбөрийг” гэсний өмнө “уг” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“32.1.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байх бөгөөд мөрийн хөтөлбөр нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын биелэлтийг хангахад чиглэсэн байна.”

**3 дугаар зүйл.**Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсгийн “32.2, 32.3-т” гэснийг “32.1-32.3-т” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЙМАГ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн





“мөрийн” гэсний дараа “хөтөлбөрөө Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон уг” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“33.1. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байх бөгөөд мөрийн хөтөлбөр нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын биелэлтийг хангахад чиглэсэн байна.”

**3 дүгээр зүйл.** Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсгийн “33.2, 33.3-т” гэснийг “33.1-33.3-т” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17 дахь заалтын “орсон” гэсний дараа “зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон” гэж, 15.1.18 дахь заалтын “мөрийн” гэсний дараа “хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхэд болон сонгуулийн мөрийн” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “тогтоомж,” гэсний дараа “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.** Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.** Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж

2.1. Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж нь Эрчим хүчний тухай хууль<sup>1</sup>, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль<sup>2</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

<sup>1</sup> Эрчим хүчний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 5 дугаарт нийтлэгдсэн.



### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“эрчим хүч” гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.1-д заасныг;

3.1.2.“эрчим хүч хэмнэлт” гэж эрчим хүч хэмнэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний эхний болон дараах эрчим хүчний хэрэглээнд хэмжилт буюу тооцоогоор гарсан зөрүүг;

3.1.3.“эрчим хүчний үр ашиг” гэж бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ашигтай хэрэглэсэн эрчим хүчийг нийт зарцуулсан эрчим хүчинд харьцуулсан харьцааг;

3.1.4.“эрчим хүчний аудит” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний хэрэглээнд шинжилгээ хийж үр ашгийг тооцох, дүгнэлт гаргах, эрчим хүч хэмнэх зөвлөмж өгөх хараат бус үйл ажиллагааг;

3.1.5.“эрчим хүчний аудитын байгууллага” гэж энэ хуулийн 3.1.4-т заасан эрчим хүчний аудитын үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийг;

3.1.6.“эрчим хүчний аудитор” гэж эрчим хүчний аудитын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэнийг;

3.1.7.“эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага” гэж үүрэг хүлээсэн хэрэглэгч болон хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх ажил гүйцэтгэх, үйлчилгээг үзүүлэх эрх бүхий аж ахуйн нэгжийг;

3.1.8.“үүрэг хүлээсэн хэрэглэгч” гэж эрчим хүчний хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс давсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг;

3.1.9.“эрчим хүч хэмнэлтийн менежер” гэж энэ хуулийн 3.1.8-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр ажиллах эрх бүхий ажилтныг.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

#### **4 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх**

4.1.Улсын Их Хурал эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг тодорхойлно.



## **5 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

5.1.Засгийн газар эрчим хүч хэмнэлтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, хангах;

5.1.2.эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлах;

5.1.3.энэ хуулийн 9.1.9-т заасан журам батлах.

## **6 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

6.1.Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

6.1.2.эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр бараа бүтээгдэхүүн, материал, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон эрчим хүч хэрэглэх машин, тоног төхөөрөмж, барилга байгууламж, ажил, үйлчилгээнд мөрдөх норм батлах, стандарт батлуулах;

6.1.3.эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.

## **7 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**

7.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангана.

7.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг тодорхойлж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

7.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.



## **8 дугаар зүйл. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл**

8.1. Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрхийг Эрчим хүчний зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

8.2. Эрчим хүчний зохицуулах хорооны бүтцэд эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй тусгайлсан нэгж байна.

## **9 дүгээр зүйл. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн бүрэн эрх**

9.1. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

9.1.2. эрчим хүч хэмнэлтийн талаар үндэсний хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулах;

9.1.3. үүрэг хүлээсэн хэрэглэгчээс эрчим хүчний хэрэглээ, хэмнэлтийн талаар хийсэн ажлын жилийн тайлан, гүйцэтгэлийг гаргуулж авах;

9.1.4. үүрэг хүлээсэн хэрэглэгчийг бүртгэх;

9.1.5. эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох;

9.1.6. эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх олгох;

9.1.7. эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээллийн систем бүрдүүлэх, энэ талаар нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.8. эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.9. дараах журмыг боловсруулах ажлыг зохион байгуулах:

9.1.9.а. энэ хуулийн 13.3, 13.4-т заасан үйл ажиллагаатай холбогдсон эрчим хүчний аудит хийх журам;

9.1.9.б. эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэхтэй холбоотой журам;

9.1.9.в. эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгохтой холбоотой журам;

9.1.9.г. эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний



хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам;

9.1.9.д.үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө, боловсруулах аргачлал, тайлагнах журам;

9.1.9.е.эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журам;

9.1.9.ж.холбогдох бусад дүрэм, журам.

9.1.10.эрчим хүчний хэмнэлтийн бодлого, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт тайлагнах;

9.1.11.эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбогдон гарсан аливаа маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх.

9.2.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь энэ хуулийн 9.1.7, 9.1.8-д заасан бүрэн эрхийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **10 дугаар зүйл. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрх, үүрэг**

10.1. Үүрэг хүлээсэн хэрэглэгч дараах эрхтэй:

10.1.1. эрчим хүчний аудитын байгууллагыг сонгох;

10.1.2. эрчим хүчний аудитын зөвлөмж, дүгнэлтийн талаар үндэслэлтэй тайлбар өгөхийг шаардах;

10.1.3. энэ хуулийн 13.4.2-т заасан зөвлөмжийг сонгон хэрэгжүүлэх;

10.1.4. эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд урамшуулал эдлэх.

10.2. Үүрэг хүлээсэн хэрэглэгч дараах үүрэгтэй:

10.2.1. эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх;

10.2.2. эрчим хүчний хэрэглээнд эрчим хүчний аудит хийлгэх;

10.2.3. өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

10.2.4. эрчим хүчний аудитын тайлан, эрчим хүч хэмнэлтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх;



10.2.5.эрчим хүч хэмнэлтийн менежерийг томилох, чөлөөлөх, энэ тухай Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэх;

10.2.6.эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон гомдлыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх.

### **11 дүгээр зүйл.Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын бүрэн эрх**

11.1.Иргэн, аж ахуй нэгж, байгууллага дараах эрх, үүрэгтэй:

11.1.1.эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас зөвлөгөө авах;

11.1.2.сайн дурын үндсэн дээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийлгэх.

### **12 дугаар зүйл.Урамшуулал**

12.1.Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшууллыг энэ хуулийн 9.1.9.е, Агаарын тухай<sup>3</sup> хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.8, 6.1.11-д заасан журмаар зохицуулна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

### **13 дугаар зүйл.Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитор**

13.1.Эрчим хүчний аудитын байгууллага магадлан итгэмжлэлийн үндсэн дээр эрчим хүчний аудитын үйл ажиллагаа явуулна.

13.2.Эрчим хүчний аудитын үйл ажиллагааг энэ хуулийн 9.1.9.а-д заасан журмаар зохицуулна.

13.3.Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитор дараах эрхтэй:

13.3.1.эрчим хүчний аудитын үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай тайлбар, материалыг үүрэг хүлээсэн хэрэглэгчээс гаргуулж авах;

13.3.2.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр эрчим хүчний хэрэглээнд аудит хийх, дүгнэлт гаргах.

<sup>3</sup> Агаарын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.



13.4.Эрчим хүчний аудитын байгууллага, эрчим хүчний аудитор дараах үүрэгтэй:

13.4.1.үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээ, үр ашгийг тооцох, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах;

13.4.2.үүрэг хүлээсэн хэрэглэгчид эдийн засгийн үр ашигтай, техникийн үндэслэлтэй зөвлөмжийг гаргаж өгөх;

13.4.3.үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хүсэлтээр зөвлөмж, дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлах.

#### **14 дүгээр зүйл. Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага**

14.1.Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь магадлан итгэмжлэлийн үндсэн дээр эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дэмжих чиглэлээр үйл ажиллагааг явуулна.

14.2.Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

14.3.Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага нь үр ашгийн үйлчилгээ үзүүлэхдээ хөрөнгө оруулалт хийж болох ба эрсдэлийг хариуцна.

#### **15 дугаар зүйл. Эрчим хүч хэмнэлтийн менежер**

15.1.Эрчим хүч хэмнэлтийн менежер нь эрхээ баталгаажуулж гэрчилгээ авсан байна.

15.2.Эрчим хүч хэмнэлтийн менежер дараах эрх, үүрэгтэй:

15.2.1.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс тодорхойлсон үйл ажиллагааны чиглэлийг мөрдөж ажиллах;

15.2.2.эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх талаар үүрэг хүлээсэн хэрэглэгчийн төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах;

15.2.3.үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих;

15.2.4.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд жил бүр ажлаа тайлагнах;

15.2.5.Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдах.





**ТАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**16 дугаар зүйл. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль  
тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1. Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан доор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

16.1.1. энэ хуулийн 10.2-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

16.2. Эрчим хүчний аудитын байгууллага, мэргэжлийн байгууллага болон эрчим хүчний аудитор нь эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээг хангалтгүй үзүүлсэн нь нотлогдож иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хохирол учруулсан бол буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж, магадлан итгэмжлэлийг цуцална.

**17 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

17.1. Энэ хуулийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.17 дахь заалтад “-эрчим хүч хэмнэлтийн бодлого” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг ашиглах тухай Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банк хооронд 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар  
хот

### Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хавсралтаар баталсугай.

2.Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /С.Батболд/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Монгол Улсын Их Хурлын 2015 оны  
104 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР  
БАРИМТЛАХ БОДЛОГО**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чухал үүрэгтэй эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь салбарын нэг мөн.

1.2.Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдэнэ.

1.3.Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг оновчтой зохицуулалтаар төрөөс дэмжихдээ дараах зарчмыг баримтална:

1.3.1.хүн амыг шим тэжээллэг, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангасан байх;

1.3.2.хүний нөөцийг тасралтгүй чадавхжуулсан байх;

1.3.3.үйлдвэрлэл нь судалгаа ба хөгжилд тулгуурласан байх;

1.3.4.хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, хамгаалсан байх;

1.3.5.үйлдвэрлэлийг үнэ цэнийн сүлжээгээр хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн байх;

1.3.6.эрсдлийг бууруулахад чиглэгдсэн байх.

1.4.Төрөөс хүнс, хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд дараах чиглэлийг баримтална:

1.4.1.уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх;

1.4.2.уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон дэвшилтэт технологид суурилсан тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжүүлэх;

1.4.3.мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эд, байгалийн баялгийг уламжлалт болон дэвшилтэт технологиор боловсруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаатай хүнсээр хүн амыг тогтвортой хангах;



1.4.4.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн чиг баримжаатай хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх;

1.4.5.салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, үйлдвэрлэл эрхлэх менежментийг сайжруулах, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх.

### **Хоёр.Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт**

2.1.Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.1.1.мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх;

2.1.2.мал аж ахуйн салбарын хөгжил дэх төрийн зохицуулалт, дэмжлэгийн чиглэл, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үүрэг, хариуцлагын оновчтой тогтолцоог бий болгох;

2.1.3.малын генетик нөөцийн бүртгэл, төлөв байдлын үнэлгээ, ашиглалт, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох, мал аж ахуй эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах;

2.1.4.малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх;

2.1.5.мал, амьтны үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулж, бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийг бий болгон, генийн санг хамгаалах болон малын нөхөн үржүүлгийг сайжруулахад био технологийн ололтыг ашиглах, малын үржүүлэг, технологийн орон нутгийн нэгжүүдийг чадавхжуулах;

2.1.6.мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авах, эрүүлжүүлэх стратегийг бүсчлэн хэрэгжүүлэх, халдварт өвчний тохиолдлыг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадавхыг сайжруулах, халдварт өвчингүй тайван байдлыг тодорхой бүс нутгаар баталгаажуулах;

2.1.7.олон улсын жишиг, шаардлагад нийцсэн мал эмнэлгийн албаны үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог сумын түвшин хүртэлх бүх шатанд бүрдүүлэх, орон нутгийн мал эмнэлгийг чадавхжуулж, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх;

2.1.8.мал эмнэлгийн үйлчилгээнд зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх;



2.1.9.эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлснээс бусад бэлчээрийг төрийн эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалттайгаар ашиглуулах, эрчимжсэн мал аж ахуйд тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулах;

2.1.10.бэлчээр болон байгалийн бусад нөөцийн зохистой ашиглалт, бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх;

2.1.11.бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл, сүргийн бүтцийг тохируулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох, бэлчээрийг оновчтой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

2.1.12.бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэх арга хэмжээг байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан өргөжүүлэх;

2.1.13.бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах малчид, иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих;

2.1.14.малын тэжээл, био бордоо, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тэдгээрт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, нутагшуулах;

2.1.15.мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр, цехийг бүсчилж хөгжүүлэх;

2.1.16.малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг түүний чанар, аюулгүй байдалтай уялдуулах;

2.1.17.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн бага ашиглалттай байгаа нөөцийн (дотор мах, дайвар бүтээгдэхүүн, хонь, ямаа, ингэний сүү гэх мэт) боловсруулалтыг нэмэгдүүлэх.

### **Гурав.Тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт**

3.1.Тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1.тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж, үр ашигтай ашиглах, бүртгэл, хяналтыг сайжруулах, тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжсэн мал аж ахуйтай хослон хөгжүүлж, тэдгээрийг эрхлэх бүс нутгийг тогтоох;

3.1.2.төвийн бүсэд тариалангийн газрын боломжит орон зайн ашиглалтыг сайжруулах, баруун, зүүн бүсэд атаршсан газрыг эргэлтэд оруулах;

3.1.3.хөрс боловсруулах тэг элдэншүүлгийн технологийг үйлдвэрлэлд үе шаттайгаар бүрэн нэвтрүүлэх болон тариалангийн газрын хөрсийг салхи, усны элэгдэл, эвдрэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх;



3.1.4.таримлын сэлгээний ээлжийн тоог нэмэгдүүлж, цулгуй уриншийн хэмжээг бууруулах, эрчимжсэн мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн түүхий эдийн хангамж, гадаад зах зээлийн хэрэгцээнд тулгуурлан таримлын зохистой сэлгээг мөрдөж, сэлгээнд тариалсан ашигт таримлыг зах зээлд нийлүүлэхийг дэмжих;

3.1.5.эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал, сортыг нутагшуулах, бүс нутгийн хөрс, цаг уурын онцлог тохирсон ирээдүйтэй, баталгаажсан таримлын үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн үрээр хангах, үр, сортын тариалан, үрийн аж ахуйн тогтолцоог сэргээн хөгжүүлэх;

3.1.6.хөрсний бүтэц, үржил шимд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан машин, тракторыг сонгож парк бүрдүүлэх, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, техникийн засвар үйлчилгээний тогтвортой сүлжээ байгуулах, зарим машин, багаж, эд ангийг дотооддоо үйлдвэрлэх, угсрах үйл ажиллагааг дэмжих;

3.1.7.усны хайгуул, судалгаанд тулгуурлан гадаргын болон бороо, цасны усыг хуримтлуулах, услалтын системийн ашиглалтыг сайжруулах, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;

3.1.8.төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад ус, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй дуслын болон хөрсөн доороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

3.1.9.ургамлын өвчин, хортон шавж, хог ургамал, мэрэгч амьтны тархалт, хор хөнөөлийн судалгаанд тулгуурлан химийн гаралтай бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг төлөвшүүлэх;

3.1.10.жимс, жимсгэний тариалалт, нэр төрлийг нэмэгдүүлэх;

3.1.11.үр тариа, буурцагт болон бусад таримлын төрөл, сортыг нэмэгдүүлэх, буудай, төмс, хүнсний ногоо, тосны ургамлын үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортын чиг баримжаатайгаар хөгжүүлэх;

3.1.12.эрчимжсэн мал аж ахуйг бүх төрлийн тэжээлээр хангах, уургийн өндөр агууламжтай таримлыг нутагшуулах, сортын үрийн нөөц бүрдүүлэх;

3.1.13.өвөл, зуны хүлэмжийн болон зоорийн аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хот, суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах.

### **Дөрөв.Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэл**

4.1.Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1.1.Монгол Улсын хүнсний хангамжийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, төлөв байдлыг үнэлэх, хүрэх түвшинг тодорхойлох;



4.1.2.эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих;

4.1.3.стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх;

4.1.4.үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх;

4.1.5.мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, анхан шатны болон хагас боловсруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;

4.1.6.хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх;

4.1.7.хүнсний сүлжээний бүх үе шатанд хадгалалт, тээвэрлэлтийн стандарт, шаардлага хангасан ложистик сүлжээг хөгжүүлэх;

4.1.8.мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, шилжилт, хөдөлгөөнийг хянах бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг сайжруулах;

4.1.9.малын эм, бордоо, ургамал хамгааллын бэлдмэл, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх үлдэгдэл бодис, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох чадавх, хяналтыг сайжруулах;

4.1.10.хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэх, дэвшилтэт технологийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжих;

4.1.11.хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулж байгаа зөрчилд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх, зөрчилтэй эвлэрсэн ойлголт, хандлагыг өөрчлөх, тавигдах шаардлагыг өндөрсгөх, нутгийн захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүнтэй арга хэлбэрийг хэвшүүлэх;

4.1.12.хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлого, халдварын тохиолдол, онцгой нөхцөл байдал, хямрал үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, салбар дундын зохицуулалтыг идэвхжүүлэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг хязгаарлах, хэрэглээнд нөлөөлөх, дэлхий нийтээр хэрэглээнээс хасаж байгаа өргөн



хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, импорт, худалдааг хориглох;

4.1.13.шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, судалгааны дүнд суурилан зохицуулах үйлчилгээтэй хүнсийг үйлдвэрлэлд турших, нэвтрүүлэх;

4.1.14.нийтийн хоол үйлдвэрлэлийн хоолны шим тэжээл, чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах, нийтийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох;

4.1.15.нийтээр нь үйлчлэх (сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цэргийн анги, хорих газар тэдгээртэй адилтгах бусад) хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, шим тэжээлийн агууламжийг дээшлүүлэх, нэгдсэн жор, технологийг боловсруулах, мөрдүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх, дотоод хяналтыг сайжруулах;

4.1.16.нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, хагас боловсруулсан бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн хүнсний хангамжийн ложистикийг бий болгох, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх;

4.1.17.мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, экспорт, импорт, хүн амын хүнсний хэрэглээний нэгдсэн мэдээллийн сан, сүлжээ бий болгох, хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлттэй холбох;

4.1.18.хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх.

### **Тав.Судалгаа ба хөгжил**

5.1.Хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа ба хөгжлийн талаар дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

5.1.1.салбарын судалгаа ба хөгжлийн тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх, шинжлэх ухаан, технологийн үр дүн, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд оролцогч талуудын уялдааг сайжруулах;

5.1.2.нээлттэй лабораторид суурилсан био, нано технологийг хөгжүүлж оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх;

5.1.3.шинжлэх ухаанд суурилсан ногоон үйлдвэрлэл, бизнес, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх;

5.1.4.шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн технологийн инкубатор, загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5.1.5.салбарын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны материаллаг орчныг бэхжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч орны зээл тусламжийн хөрөнгийг нэмэгдүүлэх;





5.1.6. олон улсын жишигт хүрсэн түвшний судалгааны нарийвчилсан арга, технологийг эзэмшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх, салбарын чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхийг дэмжих.

### **Зургаа. Хөрөнгө оруулалт, худалдаа**

6.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулах, худалдааг хөнгөвчлөх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

6.1.1. улсын төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг улсын төсвийн 3-4 хувьд хүргэх;

6.1.2. орон нутгийн төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг хоёр дахин нэмэгдүүлэх;

6.1.3. үнэ цэнийн сүлжээний санхүүжилтийн цогц бүтцийг бий болгож, шаардлагатай шатанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

6.1.4. хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, үнэ цэнийн сүлжээг тэргүүлэгч аж ахуйн нэгжээр дамжуулан хөгжүүлэх;

6.1.5. эрсдлийг бууруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоог цогц байдлаар нэвтрүүлэх;

6.1.6. дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нутагшуулах, салбарын судалгаа ба хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих;

6.1.7. хүнс, хөдөө аж ахуйн салбарт санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, төлөвшүүлэх;

6.1.8. хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг бүс нутаг, ач холбогдол, чанар, бусад хүчин зүйлд суурилан эрэмбэлэн дэмжих;

6.1.9. уул уурхайн татварын орлого, нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа хөгжлийн сан бүрдүүлж, зарцуулах;

6.1.10. дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг түүхийг эдээр хангах үйл ажиллагааг дэмжих.

6.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх:

6.2.1. дотоодын үйлдвэрлэлийг төрийн дэмжлэг, тарифын болон тарифын бус зохицуулалтаар хамгаалах;

6.2.2. хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийг тэлэх, экспортыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах;

6.2.3. бүс нутгийн болон олон улсын байгууллагад гишүүнээр элсэх;



6.2.4.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэг цонхны бодлогоор явуулах;

6.2.5.хөдөө аж ахуйн чөлөөт бүсийг байгуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, алслагдсан бүс нутагт экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих;

6.2.6.мал, амьтан, таримал ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний стандартыг шинэчлэх, нутагшуулах, тэдгээрийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах тогтолцоонд шилжүүлэх;

6.2.7.хөдөө аж ахуйн гаралтай газар зүйн заалттай, органик, брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих;

6.2.8.гадаад оронтой байгуулсан мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хэлэлцээрийн нөхцөлийг сайжруулах, шинэчлэх, шинээр байгуулах.

### **Долоо.Хүний нөөц**

7.1.Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

7.1.1.ажиллагсдын ахуй амьдралаа сайжруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдах, үйлдвэрлэлээ өргөтгөх, хорших санаачилгыг дэмжих, таатай нөхцөлийг бүрдүүлэх;

7.1.2.малчин, мал зүйч, зохиомол хээлтүүлгийн техникч, малын эмчийн хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамааруулах, гэрээт ажилчид, малчдын нийгмийн хамгааллын баталгааг ажил олгогчоор хангуулах;

7.1.3.малчин, мал бүхий этгээдийн өмч хөрөнгийг сайн дурын болон албан журмын даатгалд даатгуулах хүрээг нэмэгдүүлж болзошгүй эрсдлээс хамгаалах;

7.1.4.малчид, тариаланчдын ая тухтай амьдрах, тогтвортой ажиллах нөхцөлийг сайжруулах, малчин эмэгтэйчүүд, залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх;

7.1.5.агрономич, механикжуулагч, инженер техникийн ажилтныг тариалангийн аж ахуйн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан бэлтгэх, сургалтын орчныг сайжруулах, сургалтын агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагыг сургалттай хослуулахад чиглүүлэх;

7.1.6.салбарын мэргэжилтэн, инженер техникийн болон бусад мэргэжилтэй ажилтны төгсөлтийн дараах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах зайн сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, мэргэшлийн зэрэг олгох;

7.1.7.малчид, тариаланчдад үйлдвэрлэл, технологи, бизнес, байгаль, цаг уурын өөрчлөлтийн талаар зохистой мэдлэг олгох сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу мэдээллийн болон бусад хэрэгслийг ашиглан тасралтгүй явуулах;



7.1.8. нүүдлийн соёл, иргэншил, уламжлалд суурилсан аялал, жуулчлалыг малчдын ахуй амьдралд түшиглэн хөгжүүлэх.

**Найм.Хүрэх үр дүн**

Д/д	Шалгуур үзүүлэлт	2014 суурь он	2020 он	2025 он
1	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлт (хувиар)	12	15	20
2	Нийт төсөвт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь	2	3	4
3	Нийт сүрэгт үхрийн эзлэх хувь	6.7	8	10
4	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах /мянган тонн/	16.8	100	200
5	Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь	9	30	50
6	Эргэлтийн талбай /мянган га/	769	960	1050
7	Буудайн га-гийн ургац /центнер/	16.9	17.3	20
8	Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин (хувиар)	54	70	100
9	Тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээлийн эзлэх хувь	0.7	5	10

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

**Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:



1/Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад мөрдөгдөж байгаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаарх тогтоол, шийдвэр, заавар, журмыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэх, хуульд заасан журам, зааврыг боловсруулж батлах ажлыг 2016 оны 2 дугаар улиралд багтаан гүйцэтгэх;

2/Монгол Улсын Их Хурлаас баталсан хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, дүнг 2016 онд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;

3/хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 12 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар  
хот

**Ерөнхийлөгчийн хоригийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 94 дүгээр тогтоолд тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсугай.

2.Энэ тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар  
хот

### **Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай**

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Чөлөөлөгдөх тухай хүсэлтээ ирүүлсэн тул Жанчивдоржийн Батбаяр, Домбонгийн Үүрийнтуяа нарыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр Даваагийн Ганбаяр, Лхагвын Ганпүрэв нарыг томилсугай.

3.Энэ тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар  
хот

### **Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг батлах саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 180

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Камбожийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазарыг эгүүлэн татаж, Камбожийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лодойдамбын Галбадрахыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр  
сарын 2-ны өдөр

Дугаар 430

Улаанбаатар  
хот

### Гэрээний загвар батлах тухай

Газрын тосны тухай хуулийн 7.1.13, 11.2.17-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон сум, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээ”-ний загварыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**УУЛ УУРХАЙН САЙД**

**Р.ЖИГЖИД**



Засгийн газрын 2015 оны 430 дугаар  
тогтоолын хавсралт

## **БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

Энэхүү гэрээг нэг талаас ..... аймаг, (хотын) ..... сум (дүүрэг)-ын Засаг дарга ..... (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ..... талбайд газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 20... оны ... дугаар сарын ...-ны өдөр ..... аймаг (хот)-т байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь талууд Газрын тосны тухай хууль, бусад хууль тогтоомж болон ..... талбайд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, газрын тосны ашиглалтын үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “.....” талбайд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу орон нутаг хөгжүүлэх урамшуулалд зориулан ..... ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг жил бүр тухайн орон нутгийн хөгжлийн санд төлнө.

1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум (дүүрэг)-ын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээтэй холбогдуулан Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд газрын тос ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулж, зарцуулалтын тайланг сум (дүүрэг)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;



2.1.3. гэрээний 2.1.2-т заасан тайланг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлэх;

2.1.4. орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүний ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэх;

2.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах талаарх мэдээллийг иргэдэд хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.1.6. тухайн орон нутгийн иргэн, хуулийн этгээдээс нийлүүлэх боломжтой бараа, ажил, үйлчилгээг тусгай зөвшөөрөл эзэмшигчид санал болгож уг бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нь зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэх;

2.1.7. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгаль орчны аудит хийлгэсэн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

2.1.8. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

#### Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээтэй холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. ашиглалтын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн байгууллага, иргэдийн зүгээс саад учруулсан тохиолдолд Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уг асуудлыг зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт болон орон нутгийг хөгжүүлэх талаар хамтран хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний биелэлттэй танилцах;

3.1.3. бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч аж ахуй нэгж, иргэдэд тэргүүн ээлжинд санал болгох;

3.1.4. ашиглалтын үйл ажиллагааны явцад тусгай зөвшөөрөлтэй талбайд орших түүх, соёлын дурсгалт зүйл, булаг шанд бүхий газрыг хөндөхгүй байх;

3.1.5. гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх.





Дөрөв. Төсөл, арга хэмжээ  
хэрэгжүүлэх, тайлагнах

4.1. Талууд тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг сонгож, сайн дурын үндсэн дээр хамтран хэрэгжүүлнэ.

4.2. Энэхүү гэрээний 4.1-д заасан төсөл, арга хэмжээний санхүүжилт нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу орон нутгийг хөгжүүлэх урамшуулалд төвлөрүүлсэн хөрөнгөд хамаарахгүй.

4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 4.1-д зааснаас бусад төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй.

4.4. Сумын Засаг дарга болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг дарга болон тухайн сум (дүүрэг)-ын иргэдэд дараа оны 1 дүгээр сард багтаан тайлагнана.

4.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 4.4-т заасан тайланг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Тав. Хариуцлага, хяналт

5.1. Энэхүү гэрээний 4.1-д заасан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

5.2. Энэхүү гэрээний хэрэгжилтэд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

5.3. Талууд нь энэхүү гэрээний 4.4-т заасан тайланг өөрийн цахим хуудсанд байршуулж мэдээлнэ.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол гомдлоо шүүхэд гаргаж болно.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох

7.1. Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс ... жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.



7.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

7.3. Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэнэ. Шаардлагатай бол монгол, англи хэл дээр үйлдэж болох бөгөөд зөрүү гарвал монгол эхийг баримтална.

### НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

8.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

8.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

..... АЙМАГ /ХОТ/-ЫН, .....СУМ ..... КОМПАНИЙН  
/ДҮҮРЭГ/-ЫН ЗАСАГ ДАРГА ЗАХИРАЛ

/...../

/...../

/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг,  
тамга, тэмдэг/

/эцэг/эх/-ийн нэр, нэр, гарын үсэг,  
тамга, тэмдэг

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

**Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэг,  
Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн  
зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг  
зөрчсөн эсэх маргааныг эцэслэн  
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 14.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Н.Жанцан, Т.Лхагваа, Ш.Цогтоо, Д.Сугар /илтгэгч/, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй,



хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн А.Базар, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайхан нар оролцож, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэг; Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2; 30 дугаар зүйлийн 30.1, 30.3, 30.4; 33 дугаар зүйлийн 33.1; 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй.” гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэв. Мөн Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 13 дугаар дүгнэлтийн тухай” 88 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд оршин суугч, иргэн А.Базар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:***

“...Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад иргэн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх үндсэн эрхтэй болохыг баталгаажуулжээ. Өмчлөх эрх нь туйлын, ноёрхлын шинжтэй байдаг. Энэ үүднээс өмчлөгч нь өмчлөлийн эд хөрөнгөө чөлөөтэй захиран зарцуулах, бусад этгээдийн хөндлөнгийн нөлөөллийг үгүйсгэх эрхтэй билээ. Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын ... бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, ... , хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх ... зарчмуудад үндэслэнэ”, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “өмчлөгч нь ... өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй ашиглах, эзэмших, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтаар баталгаажуулсан өмчлөх эрхийн агуулгыг хууль зүйн үүднээс нарийвчлан тодорхойлж бататгасан хэрэг билээ.

1. Ипотекийн зүйлийн өмчлөгч өөрчлөгдсөн ч үүрэг гүйцэтгүүлэгчийн Ипотекийн зүйлээс өөрийн шаардлагыг нэн тэргүүнд хангуулах эрх нь дуусгавар болдоггүй, шинэ өмчлөгчид хандаж уг шаардлагыг гаргах



боломжтой байдаг билээ. (Иргэний хуулийн 169.1, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 28.1) Иймд ипотекийн зүйлийн өмчлөл гуравдагч этгээдэд шилжих нь үүрэг гүйцэтгүүлэгчийн эрхийг хөнддөггүй тул өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарлах шаардлага байдаггүй. Харин ипотекийн зүйлийн өмчлөл шилжүүлэхийг барьцаалагчийн зөвшөөрлөөс хамааралтай болгосноор өмчлөгчийн өмчлөх эрх, хөрөнгийг худалдан борлуулж зах зээлээс санхүүжилт олж авах боломжийг хязгаарлах юм. Түүнчлэн, үл хөдлөх эд хөрөнгийг хоёр буюу түүнээс дээш этгээдэд давхар барьцаалсан нөхцөлд өмчлөгч нь хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэхийн тулд барьцаалагч бүрээс зөвшөөрөл авах шаардлагатай болж байгаа нь өмчлөлийг шилжүүлэхэд төвөгтэй байдал үүсгэнэ. Мөн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлж авч байгаа шинэ өмчлөгч нь өмчлөлийг цаашид шилжүүлэхийн тул мөн адил барьцаалагч нарын зөвшөөрөл шаардлагатай тул барьцааны зүйлийн өмчлөлийг шилжүүлж авахад болгоомжлох болно. Үүнээс шалтгаалан барьцааны зүйлийн зах зээлийн үнэлгээ буурах нь тодорхой. Практикт үл хөдлөх эд хөрөнгийг ихэвчлэн том хэмжээний үнийн дүнтэй, урт хугацааны зээлийн үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож барьцаалдаг. Үүнтэй холбоотой өмчлөгчийн өмчлөх эрх урт хугацаанд барьцаалагчаас хамааралтай болох үр дүн үүсч байна. Эдгээр нөхцөл байдлууд нь өмчлөгчийн өмчлөх эрх зөрчигдөж буй нөхцөлүүд болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөлийг бусдад шилжүүлэхийг барьцаалагчийн зөвшөөрлөөс хамааралтай байдлаар зохицуулсан Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэг, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийг баримтлан гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр” гэх хэсэг, 27.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй” гэж заасныг зөрчиж байна.

2. Эд хөрөнгийн өмчлөгч болохынхоо хувьд өөрийн өмчлөлийн хөрөнгийг хэд хэдэн этгээдэд давхар барьцаалах эрхтэй. Хөрөнгийг хэд хэдэн этгээдэд барьцаалсан нөхцөлд барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч нар нь барьцаа үүссэн дарааллын дагуу өөрсдийн шаардлагаа хангуулах эрхтэй (Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 33.2, Иргэний хуулийн 158.5 дахь хэсэг) болохын хувьд барьцаалсан хөрөнгийг давхар барьцаалах нь өмнөх барьцаалагчийн эрхийг хөнддөггүй. Өөрөөр хэлбэл, барьцаалагч этгээд өөрөөс нь хожуу барьцааны эрх олж авсан этгээдээс түрүүлж шаардлагаа хангуулах эрхтэй тул барьцаалсан хөрөнгийг гуравдагч этгээдэд давхар барьцаалах нь түүний эрхийг хөнддөггүй. Харин давхар барьцаалахыг хориглох, хязгаарлах тохиолдолд хөрөнгийн



өмчлөгчийн өмчлөх эрх зөрчигдөх болно. Ялангуяа зээлийн үнэлгээний харьцаа /зээл, түүний үлдэгдлийн дүнг барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд харьцуулсан хувь/ бага байх тохиолдолд уг эд хөрөнгийг давхар барьцаалах эрэлт зах зээлд байсаар байдаг тул давхар барьцаалахыг барьцаалагчийн зөвшөөрлөөс хамааралтай болгосноор өмчлөгч нь өмчлөлийн хөрөнгөө давхар барьцаалан зах зээлээс санхүүжилт олж авах тэрхүү боломжийг хязгаарлах болно...

3. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг үндсэн үүргийг гүйцэтгэх хугацааны дотор гуравдагч этгээдэд барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр түрээслэх, хөлслөх, үнэ төлбөртэйгээр түр ашиглуулахаар бусдын эзэмшилд шилжүүлэх эрхтэй”, 30.3 дахь хэсэгт “Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар бусдад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна”, 30.4 дэх хэсэгт “Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна”, Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна” гэж өмчлөгчийн Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд байгуулах аливаа хэлцэл, ипотекийн зүйлийг бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг барьцаалагчийн зөвшөөрлөөс хамааралтай болгожээ. Ингэснээр барьцаалагч уг зөвшөөрлийг олгоход өмчлөгчөөс төлбөр шаардах, барьцаалагч зөвшөөрөл өгөөгүйгээс өмчлөгч өөрийн хөрөнгийн ашигтай байдлыг гаргаж чадахгүй байх буюу хөлслөх, түрээслэх зэргээр ашиг орлого олж чадахгүй байх үр дагаварт хүргэж байна. Учир нь, барьцаалагчийн үндсэн эрх нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй нөхцөлд ипотекийн зүйлийг худалдан борлуулах замаар өөрийн шаардлагаа хангуулах явдал байдаг бөгөөд ипотекийн зүйлийг гуравдагч этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах нь барьцаалагчийн энэхүү эрхийг хөндөхгүй юм. Иргэний хуулиар ипотекийн зүйлийн чанар, арчлан хамгаалалтын нөхцөлийг шалгах (Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 24.1), ипотекийн зүйлд аюул учрах бодит нөхцөл байдал бий болсон бол өмчлөгчид уг аюулыг зайлуулахыг үүрэг болгох, өмчлөгч аюулыг зайлуулах арга хэмжээ аваагүй бол ипотекийн зүйлээс өөрийн шаардлагыг нэн даруй хангуулах (Иргэний хуулийн 170.2), өмчлөгч ипотекийн зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах талаар хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэхгүй байх тохиолдолд эд хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэхийг шаардах (Иргэний хуулийн 170.5), үүнтэй холбогдон



гарсан зайлшгүй зардлаа шаардах (Иргэний хуулийн 157.1.5), ипотекийн зүйлийг даатгуулахыг гэрээ байгуулах үед өмчлөгчид үүрэг болгох, устгах тохиолдолд даатгалын нөхөн төлбөр Ипотекийн зүйлийг сэргээн засварлалтад ашиглагдах эсэхэд хяналт тавих (Иргэний хуулийн 170.3), даатгалын нөхөн төлбөрөөс өөрийн шаардлагаа хангуулах (Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 22.2), барьцаагаар баталгаажсан шаардлагыг хангахад зайлшгүй шаардлагатай үйлдэл хийхийг өмчлөгчөөс шаардах, өмчлөгч уг үйлдлийг хийгээгүй тохиолдолд өмчлөгчийн нэрийн өмнөөс уг үйлдлийг хийх зэрэг эрхтэй (Иргэний хуулийн 158.4) байна.

Иймд барьцаалагчийн эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай бус, өмчлөгч өөрийн үл хөдлөх эд хөрөнгийг гуравдагч этгээдэд ашиглуулах, эзэмшүүлэх эрхийг хязгаарласан Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй гэж заасныг зөрчиж байна.

4.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт өмчлөгч нь барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр газар дээр барилга байгууламж барих талаар зохицуулсан нь мөн өмчлөгчийн хөрөнгөө захиран зарцуулах эрхийг нь хязгаарлаж байна. Тодруулбал, Иргэний хуулийн 171 дүгээр зүйл (өмчлөгчийн хэлцэл хийх эрхийг үл хязгаарлах)-ийн 171.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна” гэж заасан байна. Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэг нь Иргэний хуулийн дээрх заалттай зөрчилдөөнтэй заалт байх бөгөөд Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалтыг батлах үндэслэл болсон байна. Иймд Иргэний хуулийн болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалт Иргэний хууль ипотекийн талаарх “өмчлөгчийн хэлцэл хийх эрхийг хязгаарлахгүй байх” үзэл баримтлал, зохицуулалттай зөрчилдсөн төдийгүй Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн байна.

Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн “Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоол, 5 дугаар сарын 30-ны өдрийн “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам батлах тухай” 200 дугаар тогтоол батлагдаж иргэдийг урьдчилгаа төлбөр болон зээлийн хүү бага, урт хугацаатайгаар орон сууцны ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ



авсан билээ. Тэр хэмжээгээр ч иргэд банкны орон сууц барьцаалсан зээлд өргөн хамрагдаж байгаа. Иймд Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн холбогдох заалтаас болж тэр олон зээлдэгч иргэний өмчлөх эрх хөндөгдөж байгаа. Энэ харилцаанд гэрээний нэг талд сул тал болох сонголт, боломж, санхүүжилт хязгаарлагдмал, зээл хүсч буй иргэн, нөгөө талд нь тухайн зах зээлийн мэргэжлийн этгээд болох банк байх бөгөөд гэрээ нь банкны урьдаас бэлдсэн стандарт нөхцөлийн дагуу байгуулагдаж байна.

Иймд Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэг; Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27.1 дэх хэсгийн “Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийг баримтлан ... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр” гэх заалт, 27.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр” гэх заалт, 30.3, 30.4 дэх хэсэг, 33.1 дэх хэсгийн “хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол” гэх заалт, 56.1 дэх хэсгийн “газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр” гэх заалт тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх эрхтэй” гэж заасныг зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгөхийг хүсье.” гэжээ.

***Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:***

“...Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх үндсэн эрх, түүний хувийн эрх зүйн харилцаанд хэрэгжих үндэслэлийг тодорхойлсон Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгтэй зөрчилдөхгүй юм.

Ипотекийн зүйлийн өмчлөлийн асуудалд байдаг тодорхой ашиг сонирхлыг хамгаалахад Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн “Өмчлөгчийн хэлцэл хийх эрхийг үл хязгаарлах” гэсэн гарчиг болон мөн зүйлийн доторх 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.” гэснээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 171 дүгээр 171.2 дахь хэсгийн зохицуулалт нь үл

хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, түүний дотор, ашиглах, захиран зарцуулах эрхийг хязгаарлахад чиглээгүй юм.

Харин Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг үүрэг гүйцэтгүүлэгч өгөх эсэх асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн бус, иргэний эрх зүйн тодорхой, хэрэг маргааны зүйл болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Барьцаалуулагч нь Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийг баримтлан барьцааны зүйлийг гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр бусдын өмчлөлд шилжүүлэх эрхтэй.”, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар бусдад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна.”, 30.4 дэх хэсэгт “Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.” гэх заалт дахь “барьцаалагчийн зөвшөөрөл”, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт “Барьцаалбар олгосон бол барьцааны зүйлийг уг барьцаалбараар тодорхойлсон нөхцөлийн дагуу бусдын өмчлөлд шилжүүлж болно.” гэсэн заалт нь барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдал, үүргийн гүйцэтгэлийг хангах шинж чанарыг дордуулахгүй байх барьцаалагчийн ашиг сонирхолтой холбоотой хэрэглэгдэх зохицуулалт болохоос өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарлах утгаар хэрэглэгдэхгүй болно.

Мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол барьцаалуулагч нь барьцааны зүйлийг бусад этгээдэд давхар барьцаалах эрхтэй.” гэсэн заалт нь барьцааны зүйлийг давхар барьцаалахыг хориглохоор өмчлөгч нь өөрийн хүсэл зоригт үндэслэн гэрээ байгуулсан тохиолдлыг хамарсан байх тул хүний эрхийг хуулиар хориглон хязгаарласан агуулгагүй байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт “Барьцаалуулагч нь газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр барьцаалуулсан газар дээр барилга байгууламж барих эрхтэй бөгөөд барьцааны гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаа нь тухайн барилга байгууламжид үл хамаарна.” гэж заасан нь барьцаалсан газар дээр барилга байшин баригдсанаар уг газрын чанар байдалд өөрчлөлт орж, шаардлагаа барьцаагаар хангах боломжгүй болох эрсдэлтэй холбоотой барьцаалагчийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд “барьцаалагчийн зөвшөөрөл” шаардсан агуулгатай болохоос уг газар





дээр барилга байгууламж барих өмчлөгчийн эрхийг хязгаарлан хориглох агуулгагүй юм.

Дээр дурдсаныг үндэслэн Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэг, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.3, 30.4, 33 дугаар зүйлийн 33.1, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр танд уламжилж байна” гэжээ.

***Гурав. Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 13 дугаар дүгнэлт гаргасан байна.***

**Уг дүгнэлтийн үндэслэх хэсэгт:**

“1. Өмчлөх эрх нь өмчлөгчийн язгуур эрх бөгөөд өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах ба аливаа халдлагаас хамгаалах эрхтэй.

Өмчлөгчийн эрхийг гагцхүү нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, бусдын эрхийг зөрчиж бусдад гэм хор учруулахыг хориглох, эд хөрөнгийн хязгаарлагдмал эрх бүхий этгээдэд эрхээ хэрэгжүүлэх боломж олгох зорилгын үүднээс нийтийн болон иргэний эрх зүйн хэм хэмжээгээр хязгаарладаг нийтлэг жишиг байдаг.

2. Ипотекийн зүйлийн өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх хөрөнгөө бусдын өмчлөлд шилжүүлэх, түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулахаар бусдын эзэмшилд шилжүүлэх, давхар барьцаалах, барьцаалуулсан газар дээрээ барилга байгууламж барих зэргээр туйлын эрхээ хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд ингэснээрээ барьцаалагчийн эрхийг зөрчихгүй, барьцаалагчид гэм хор учруулахгүй юм. Учир нь ипотекийн зүйлийн өмчлөл, эзэмшил хэнд шилжсэнээс үл хамааран барьцааны зүйлийг дагалдан ипотекийн эрхээ хэрэгжүүлэх давуу эрх нь барьцаалагчид хэвээр хадгалагддаг. Мөн ипотекийн зүйлийг давхар барьцаалах нь ипотекаар хангагдах шаардлагаа тэргүүн ээлжинд хангуулах өмнөх барьцаалагчийн эрхийг хөнддөггүй.

3. Монгол Улсын Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна” гэж заасан нь өмчлөгчийн туйлын эрхийг баталгаажуулсан үндсэн зохицуулалт юм.

Мөн зүйлийн 171.2 дахь хэсэгт Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарахаар зохицуулсан нь дээр дурьдсан үндсэн зохицуулалттай зөрчилдөж байгаа бөгөөд өмчлөгчийн эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан гэж үзэхээр байна.” гээд

### **Дүгнэлт гаргах хэсэгт:**

1. Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт заасан “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”; Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 27.2 дахь хэсгийн “Барьцаалбар олгосон бол барьцааны зүйлийг уг барьцаалбараар тодорхойлсон нөхцөлийн дагуу бусдын өмчлөлд шилжүүлж болно.”, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “... барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 30.3 дахь хэсгийн “Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар бусдад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна.”, 30.4 дэх хэсгийн “Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.”, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол ...”, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “... газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй.” гэснийг зөрчсөн байна.

2. Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт заасан “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”; Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 27.2 дахь хэсгийн “Барьцаалбар олгосон бол барьцааны зүйлийг уг барьцаалбараар тодорхойлсон нөхцөлийн дагуу бусдын өмчлөлд шилжүүлж болно.”, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “... барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 30.3 дахь хэсгийн “Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар бусдад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна.”, 30.4 дэх хэсгийн “Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл



хүчин төгөлдөр бус байна.”, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол ...”, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “... газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.” гэсэн болно.

***Дөрөв. Монгол Улсын Их Хурлын “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 13 дугаар дүгнэлтийн тухай” 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 88 дугаар тогтоолд:***

“1.“Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Барьцаалбар олгосон бол барьцааны зүйлийг уг барьцаалбараар тодорхойлсон нөхцөлийн дагуу бусдын өмчлөлд шилжүүлж болно.”, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “... барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн “Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар бусдад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна.”, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.”, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол ...”, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “... газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй.” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.

***Тав.*** Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан Үндсэн хуулийн цэцэд тайлбар ирүүлсэн боловч энэхүү тайлбар нь Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгийн 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдөр ирүүлсэн тайлбартай үг өгүүлбэр, утга санаагаар бүрэн давхцсан байна.



### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Ипотекийн зүйлийг барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх, давхар барьцаалах, барьцаалсан газар дээр барилга, байгууламж барих нь тэргүүн ээлжинд үүргийн гүйцэтгэлийг хангуулах барьцаалагчийн эрхийг хөндөхгүй бөгөөд барьцааны зүйлийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, эрсдэлээс хамгаалах боломжийг Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулиар тогтоожээ.

2. Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим заалтаар барьцаалагч талд давуу байдал олгосноор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын тэгш байдлын зарчим, Үндсэн хуулиар тогтоосон өмчлөгчийн язгуур эрхэд халдсан гэж үзэхээр байна.

3. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 13 дугаар дүгнэлтийн тухай” 88 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн шийдвэрийн үндэслэлийг заагаагүй байна.

4. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 13 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл; Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг; 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:**

1. Иргэний хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2 дахь хэсэгт заасан “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна.”; Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “... гагцхүү барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 27.2 дахь хэсгийн “Барьцаалбар олгосон бол барьцааны зүйлийг уг барьцаалбараар тодорхойлсон нөхцөлийн дагуу бусдын өмчлөлд шилжүүлж болно.”; 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “... барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...”, 30.3 дахь хэсгийн “Барьцааны зүйлийг барьцаагаар хангагдах үүрэг гүйцэтгэх хугацаанаас хэтрүүлж болон өөр зориулалтаар



бусдад ашиглуулахдаа барьцаалуулагч нь барьцаалагчийн зөвшөөрлийг авна.”, 30.4 дэх хэсгийн “Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр энэ хуулийн 30.1-д заасан хугацаанаас хэтрүүлж гуравдагч этгээдэд эрх олгосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.”; 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Хүчинтэй байгаа өмнөх гэрээгээр хориглоогүй бол ...”; 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “... газар барьцаалах гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцаалагчийн зөвшөөрөлтэйгээр ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “... үл хөдлөх хөрөнгө ... өмчлөх ... эрхтэй.” гэснийг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 13 дугаар дүгнэлтийн тухай” 88 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ**

**ГИШҮҮД**

**Ж.АМАРСАНАА**

**П.ОЧИРБАТ**

**Н.ЖАНЦАН**

**Т.ЛХАГВАА**

**Ш.ЦОГТОО**

**Д.СУГАР**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.СОЛОНГО**

**Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 3.75

**Индекс: 14003**